

**2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНЫ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ЗАСАГ ДАРГААС
ООС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Агаар-12 фонтоор бичиж, 2023 оны **05 дугаар сарын 26-ны** “Баасан” гарагт e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД		
1	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны “Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг заалт тус бүрээр хангаж, ажлаа эрчимжүүлж ажиллах.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн мэдээллийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ил тод, энгийн, ойлгомжтой хэлбэрээр байршуулах. ✓ Иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх иргэдийн санал асуулгыг тогтмол авч хэвшүүлэх, түүний мөрөөр үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, хэрэгжилт үр дүнг иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлж ажиллах. ✓ 2000 оноос хойш газрын чиглэлээр гаргасан захирамж, барилгын А даалгавар болон бусад тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг https://shilen.gov.mn/сайтад байршуулах ажлуудыг эрчимжүүлж ажиллах. ✓ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийг ил тод болгох. 	ЗДТГ, ААНБ-ууд
2	“Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулахдаа, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байхад анхаарч боловсруулан 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулах.	ЗДТГ
3	“Нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож, онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа” сэдэвт стратегийн команд штабын сургуулийг ирэх зургадугаар сарын 7-9-ний өдрүүдэд зохион байгуулах бэлтгэл ажлыг бүх шатандаа сайтар анхаарч ажиллах.	ОБХ, ААНБ-ууд Ерөнхий болон дэд ажлын хэсгүүд
4	Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Турк Улсад болсон газар хөдлөлтийн тухай” гэрэл зургийн үзэсгэлэнг 2023 оны 05 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд 10.00-17.00 цагт Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдах тул Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан, албан хаагчид, гэр бүлийн хамт оролцохыг уриалж ажиллах.	ЗДТГ, ААНБ-ууд Хороод
ИРГЭДИЙН ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХИЙГ ХАНГАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД		
5	Гэр хорооллын 16 байршилд тохижилт, ногоон байгууламж бүхий бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил болон гарааш буулгаж, чөлөөлсөн талбайг тохижуулах ажлуудыг эрчимжүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, олон нийтэд тогтмол мэдээлж ажиллах.	ТХҮХ

6	“Улаанбаатар марафон 2023” өдөрлөгийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, байгууллагынхаа ажилтан, албан хаагчдыг идэвхтэй хамруулж оролцуулах.	НХХ, БТСХ, ААНБ-ууд Хороод
ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД		
7	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/96 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах.	ЗДО Б.Болормаа, Татварын хэлтэс, Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн тасаг
8	ААНБ-уудын удирдлагын үйл ажиллагааны талаар албан хаагчдаас санал, асуулга авч дүгнэж ажиллах.	ЗДТГ, ААНБ-ууд
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
9	2023 оны 06 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулагдах “Хүүхдийн баяр”-ын арга хэмжээний бэлтгэлийг сайтар ханган, тухайн өдрөөр зохион байгуулагдах арга хэмжээ, уралдаан тэмцээний аюулгүй байдалд анхаарч, шинэлэг хэлбэрээр зохион байгуулах	НХХ, ГБХЗХХ, Цагдаагийн хэлтэс
10	Дүүргийн ААНБ-уудаар аялж буй “1-рт шалга, 1-рт хүүхэд” тугийг нийт ажилтан, албан хаагчид QR кодыг уншуулан асуумжийг бөглөж, идэвхи санаачлагатай оролцох	ААНБ-ууд
11	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн асалтад анхаарч, засвар шинэчлэл хийн асалтыг 100% болгох	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
12	Дүүргийн 1, 2 дугаар хороодын лед дэлгэцийг засварлаж, ажиллуулах	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, Соёлын ордон, Хороод
13	Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой иргэдээс санал авах ажил 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 15:00 цагт 2 дугаар хорооны Клубт зохион байгуулагдах тул иргэдийг өргөнөөр оролцуулахад анхаарч ажиллах	ЗДТГ, Хороод
14	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд орчныхоо 50 м хүртэлх талбайн өнгө үзэмжийг сэргээж, хайс хашааг угаах, хогны түүвэр цэвэрлэгээг тогтмолжуулах	ААНБ-ууд
15	ААНБ-уудын удирдлагууд дүүргийн Засаг даргатай байгуулсан гэрээний төлөвлөгөөнд тусгагдсан Олон улсын байгууллагатай хамтарч төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилтын хэрэгжилтийг авч нэгтгэн, танилцуулах	
16	Он дамжин хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлууд болон 2023 онд шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлуудыг эрчимжүүлж, хөрөнгө оруулалттай холбоотой танилцуулга бэлтгэн 2023 оны 05 дугаар сарын 25-ны 10:00 цагаас өмнө танилцуулж ажиллах	ХААА